

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 01 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цаг 40 минутад эхэлж, мөн өдрийн 11 цаг 50 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 1 цаг 10 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Улсын хошой аварга малчин өрх”, “Улсын аварга малчин өрх” шалгаруулах тухай	1.“Улсын хошой аварга малчин өрх” шалгаруулах журмын шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан Ховд аймгийн Дарви сумын Баянбулаг багийн Улсын аварга малчин Рэнцэндоржийн Цэрэндорж, Үенч сумын Жаргалан багийн малчин Хинатын Бөрбай нарыг “Улсын хошой аварга малчин өрх”-өөр 2.Улсын аварга малчин өрх шалгаруулах журмын шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан Зэрэг сумын Гүвээ багийн малчин Авирмэдийн Мөнхбат, Алтай сумын Алтангадас багийн малчин Догсомын Содбилэг, Мянгад сумын Цагаанбулан багийн малчин Баатаржавын Бат-Эрдэнэ, Чандмань сумын Тахилт багийн малчин Доржийн Мөнхцоож, Ховд сумын Цагаанбургас багийн малчин Солбанбайн Бейбитхан, Мөст сумын Цэцэг гол багийн малчин Ёндонгийн Эрдэнээ, Булган сумын Байтаг багийн малчин Намжаагийн Мөнхбаяр, Буянт сумын Нарийн гол багийн малчин Батхүүгийн Дашдаваа, Дуут сумын Хөх бэлчир багийн малчин Зодовын Баатархүү нарыг “Улсын аварга малчин өрх”-өөр тус тус шалгаруулахаар дэмжиж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Гончигсүрэнд үүрэг болгов.
2	“Улсын аварга тариаланч” шалгаруулах тухай	1.“Улсын аварга тариаланч” шалгаруулах журмын шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан Ховд аймгийн Мянгад сумын Баянхошуу багийн тариаланч Даваасүрэнгийн Лхагвасүрэн, Ховд сумын Улаанбураа багийн тариаланч Адилханы Мырзахан, Жаргалант сумын Баатархайрхан багийн тариаланч Бямбын Тунгалаг, Буянт

		сумын Норжинхайрхан багийн тариаланч Жамсрангийн Түвшин-Амар, Долдойн Аманжол нарыг “Улсын аварга тариаланч”-аар шалгаруулахаар тус тус дэмжиж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Гончигсүрэнд үүрэг болгов.
--	--	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР